



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/171

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт, МУИС-ийн дүрмийн 4.3.1, 4.3.8.4 дахь хэсэг, МУИС-ийн захиргааны зөвлөлийн хурлын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улсын Их Сургуульд суралцагчдад тэтгэлэг олгох ерөнхий журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "МУИС-ийн нэрэмжит тэтгэлгийн журам"-ыг 2 дугаар хавсралтаар, "Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг"-ийг 3 дугаар хавсралтаар, "Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Б.Ринчен нарын нэрэмжит тэтгэлэг"-ийг 4 дүгээр хавсралтаар, Докторын дараах судлаачийн болон Сургалт, судалгааны туслахаар ажиллуулах тэтгэлэг-ийг 5 дугаар хавсралтаар, Докторын сургалтад суралцаж буй МУИС-ийн багшид тэтгэлэг олгох журам-ыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Монгол улсын их сургуульд суралцагчдад тэтгэлэг олгох тухай нийтлэг журам"-д нэмэлт өөрчлөлт оруулж, 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3. "Монгол улсын их сургуульд суралцагчдад тэтгэлэг олгох тухай нийтлэг журам" шинэчлэн батлагдсантай холбогдуулан МУИС-ийн захирлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/571 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Д.Бадмаанямбуу/, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлууд, алба нэгжийн удирдлагуудад даалгасугай.


ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

3340502442

Захирлын 2021 оны 01 дугаар сарын 09-ны
өдрийн 114 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДАД ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЕРӨНХИЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Их Сургуулийн (цаашид МУИС гэх) суралцагчдын амжилттай суралцах, судалгаа шинжилгээний ажилд оролцож сайн үр дүн гаргах, бүтээл хэвлүүлэх зэрэг суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тэднийг урамшуулах, шилдэг элсэгчдийг дэмжих зорилгоор МУИС-иас олгох тэтгэлэг болон гадаад дотоодын байгууллага, сан, төгсөгч, хувь хүний нэрэмжит тэтгэлгийг олгох үйл ажиллагааг зохицуулахад энэхүү ерөнхий журмын зорилго оршино.

1.2 Тэтгэлгийн зорилго, төрөл, олгох байгууллага, санхүүжилтийн эх үүсвэр, олгох хугацаа, суралцагчид тавигдах шаардлага, нөхцөл зэргээс хамааруулан бусад байгууллага, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлгийг тухайн байгууллагаас гаргасан тэтгэлэг олгоход баримтлах журам, МУИС-тай байгуулсан гэрээ, харилцан ойлголцлын санамж бичигт тусгасны дагуу зохион байгуулж олгож болно.

1.3 Энэхүү журам нь хоёр дахь дээд боловсролын зэрэг эзэмшихээр болон эцнээ, орой хэлбэрээр суралцаж буй суралцагчид хамаарахгүй.

1.4 Тэтгэлэг нь суралцагчийн сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг бүхэлд нь эсвэл тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд буцалтгүй тусламж хэлбэрээр олгогдоно.

ХОЁР. Тэтгэлгийн төрлүүд

2.1 МУИС-ийн суралцагчдад олгох тэтгэлэг нь дараах төрлүүдээс бүрдэнэ.

Үүнд:

2.1.1 МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг,

2.1.2 МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг,

2.1.3 МУИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэтгэлэг,

2.1.4 Докторын сургалтад суралцаж буй МУИС-ийн багшид олгох тэтгэлэг,

2.1.5 Докторын дараах судлаачийн болон Сургалт, судалгааны туслахаар ажиллуулах тэтгэлэг,

2.1.6 Гадаад, дотоодын байгууллага, сан, төгсөгч, хувь хүний нэрэмжит тэтгэлэг г.м.

2.2 МУИС-иас олгох тэтгэлгийн нөхцөл, тэтгэлэг горилогчид тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх, шалгаруулах, тэтгэлгийг олгох зэрэг үйл ажиллагааг энэхүү ерөнхий журмыг үндэслэн тус тусын журмаар зохицуулна. Гадаад дотоодын байгууллага, хувь хүмүүс, сангийн нэрэмжит тэтгэлгийг олгоход тавигдах шаардлага, болзол зэргийг харгалзан суралцагчийг тэтгэлэгт нэр дэвшүүлэх, анхан шатны шалгаруулалт явуулах ажлыг МУИС хариуцан зохион байгуулна.

2.3 Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг нь судалгаа, эрдэм шинжилгээний ажилд идэвхтэй оролцож онцгой амжилт гаргасан шилдэг суралцагчдад олгодог тэтгэлэг байна.

2.4 МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг нь сурлагын амжилтаар тэргүүлсэн шилдэг элсэгч, суралцагчдад олгодог тэтгэлэг байна.

2.5 Бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэтгэлэг нь сурлага, эрдэм шинжилгээний амжилт үзүүлсэн, МУИС-ийн нэрийн өмнөөс улс, олон улсын хэмжээний уралдаан, тэмцээнд оролцож урлаг, спортын амжилт гаргасан авьяаслаг суралцагчдыг дэмжих зорилгоор МУИС-ийн бусад тэтгэлэгтэй давхардуулахгүйгээр олгодог тэтгэлэг байна. Бүрэлдэхүүн, салбар сургууль нь өөрийн харьяаны сургалт-судалгааны лабораториудад сургалт, судалгааны туслахаар ажиллах ахисан түвшний оюутанд тэтгэлэг олгож болно.

2.6 Докторын сургалтад суралцаж буй МУИС-ийн багшид олгох тэтгэлэг нь МУИС-д үндсэн багшаар ажиллаж, тус сургуулийн докторын сургалтад амжилттай суралцаж буй багшид олгодог тэтгэлэг байна. Тэтгэлгийн санхүүжилтийг МУИС-ийн төсөвт тусгаж, тэтгэлэг олгох үйл ажиллагааг Ахисан түвшний сургуулиар дамжуулан хэрэгжүүлнэ.

2.7 Докторын дараах судлаачийн тэтгэлэг нь докторын зэрэгтэй, судалгаа шинжилгээний ажлын өндөр чадавхтай, МУИС дээр хэрэгжиж буй улс, олон улсын хэмжээний судалгааны ажилд оролцож тодорхой хэсгийг хариуцан ажиллах, сургалтын үйл ажиллагаанд оролцох нарийн мэргэшсэн иргэдэд олгох тэтгэлэг байна. Тэтгэлгийн санхүүжилтийг МУИС-ийн төсөвт тусгаж, тэтгэлэг олгох үйл ажиллагааг Ахисан түвшний сургуулиар дамжуулан хэрэгжүүлнэ.

2.8 Сургалт, судалгааны туслахаар ажиллуулах тэтгэлэг нь ахисан түвшний суралцагчдын судалгаа хийх, суралцах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх болон мэргэшил, ур чадварыг хөгжүүлэх, сургалт, судалгааны ажил хийх арга барилыг нь дээшлүүлэх зорилгоор олгодог тэтгэлэг байна.

2.9 Тэтгэлгийн шалгуур, баримт бичгийн бүрдүүлэлт, мөнгөн дүнгийн хэмжээ, олгох хугацаа, давтамж, тэтгэлэгт хамрагдах хүний тоо зэрэг нь тэтгэлгийн төрлөөс хамаарч харилцан адилгүй байна.

2.10 “МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг”-ийн олимпиад нөхцөл, ЭЕШ-ийн өндөр үнэлгээгээр элссэн элсэгчид болон үргэлжлэх нөхцөлтэй тэтгэлгээс бусад тэтгэлэгт хамрагдаж, суралцах хугацаандаа сургалтын төлбөрийн 12 багц цагтай тэнцэх хэмжээний тэтгэлэг авсан тохиолдолд тэтгэлгийг давхардуулж олгохгүй.

ГУРАВ. Суралцагчдад тавигдах нийтлэг шаардлага

3.1 Тэтгэлгийн шалгаруулалтад нэр дэвших суралцагч нь дараах нийтлэг шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

3.1.1 МУИС-ийн идэвхтэй төлөвийн суралцагч байх,

3.1.2 Сурлагын болон эрдэм шинжилгээний ажлын амжилт гаргасан байх,

3.1.3 Тэтгэлгийн төрлүүдийн нөхцөл, шаардлагыг хангасан байх,

3.1.4 Монгол улсын хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, журмыг зөрчиж аливаа шийтгэл хүлээж байгаагүй байх,

3.2 Тэтгэлгийн төрлүүдээс хамаараад тухайн тэтгэлгийг санхүүжүүлэгчийн нэмэлт болзол, шаардлагыг тусган оруулж болно.

ДӨРӨВ. Тэтгэлэг зарлах, материал хүлээн авах, бүртгэх

4.1 Тэтгэлгийн талаарх мэдээллийг оюутан хариуцсан нэгж болон журамд заасан холбогдох нэгжүүд хариуцан, тэтгэлэгт нэр дэвшигчийн бүрдүүлбэл зохих материалыг хүлээн авах хугацаанаас 20-оос доошгүй хоногийн өмнө суралцагчдад зарлан мэдээлж, холбогдох мэдээллийг МУИС-ийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгсэлд байршуулан мэдээлэл түгээнэ. Материал хүлээн авах эцсийн хугацааг тодорхой заасан байна.

4.2 Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг болон бакалаврын түвшний суралцагчдад олгох МУИС-ийн нэрэмжит тэтгэлгийг жилд нэг удаа, ахисан түвшний суралцагчдад олгох МУИС-ийн нэрэмжит тэтгэлгийг жилд 2 удаа тус тус зарлана. Бүрэлдэхүүн сургуулийн тэтгэлэг, гадаад дотоодын байгууллага, сан, төгсөгч, хувь хүний нэрэмжит тэтгэлгийг тус тусын журам, хамтын ажиллагааны гэрээ, санамж бичигт заасан хугацаанд зарлан хүсэлтийг хүлээн авна.

4.3 Энэ журмын 3-р бүлэгт заасан нийтлэг шаардлагыг хангасан суралцагч 4.4-д заасан материалыг бүрдүүлэн цахимаар бүртгүүлнэ. Эх материалыг зарлагдсан хугацаанд багтаан оюутан хариуцсан нэгж болон журамд заасан холбогдох нэгжид хүлээлгэн өгснөөр бүртгэл баталгаажна.

4.4 Тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргаж буй суралцагч дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

- 4.4.1 Суралцагчийн талаарх мэдээллийг агуулсан тэтгэлгийн анкет,
- 4.4.2 Сурлагын дүнгийн дэлгэрэнгүй (Оюутны бүртгэл хариуцсан нэгж тодорхойлох). Тухайн тэтгэлэгт тохирсон амжилтыг илэрхийлсэн баримт бичиг, нотолгоо, түүний хуулбар,
- 4.4.3 Мэргэжлийн профессор багшийн тодорхойлолт (шаардлагатай нөхцөлд),
- 4.4.4 Тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн тодорхойлолт (шаардлагатай нөхцөлд),
- 4.4.5 Бусад (тэтгэлгийн санхүүжүүлэгч байгууллага болон төрөл, нөхцөлөөс хамаарч бүрдүүлэх нэмэлт материал),
- 4.4.6 Нийгмийн идэвх оролцоог дүгнэсэн тодорхойлолт, бусад гэрээ.

4.5 Тэтгэлэгт хүсэлт гаргагч нь мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах ба бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэн нь илэрвэл тэтгэлэгт өрсөлдүүлэхээс татгалзах бөгөөд үүнээс үүдэн гарах хариуцлагыг суралцагч өөрөө хариуцна.

4.6 Оюутан хариуцсан нэгж материалын бүрдүүлэлт, тэтгэлгийн нөхцөл, болзол шаардлагыг хангасан байдал зэргийг нягтлан хянаж, шаардлага хангасан материалыг хүлээн авна.

4.7 Тэтгэлэгтэй холбогдолтой мэдээллийн нэгдсэн санг сургалтын СиСи мэдээллийн системтэй холбон тогтмол шинэчлэх, тэтгэлэгт хамрагдсан талаар тэмдэглэгээ хийх асуудлыг оюутан хариуцсан нэгж хариуцан мэдээг жил бүр МУИС-ийн хичээлийн жилийн тайланд тусгана. Тэтгэлгийн сонгон шалгаруулалтын дүн, шалгарсан суралцагчдын мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлнэ.

ТАВ. Суралцагчдыг сонгон шалгаруулах

5.1 Тэтгэлэгт хамрагдах суралцагчийг сонгон шалгаруулах, тэтгэлэг санхүүжүүлэгч байгууллагад анхан болон эцсийн шатны шалгаруулалтыг хийж холбогдох материалыг хүргүүлэх асуудлыг оюутан хариуцсан нэгж болон бусад холбогдох нэгж хариуцан зохион байгуулна.

5.2 МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг болон гадаад, дотоодын байгууллага сан, төгсөгч, хувь хүний нэрэмжит тэтгэлгийн сонгон шалгаруулалт явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн МУИС-ийн захирлын тушаалаар томилон ажиллуулна. Бусад тэтгэлгийн сонгон шалгаруулалт явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг холбогдох тэтгэлгийн журамд заасны дагуу томилон ажиллуулна.

5.3 МУИС-иас олгох тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг томилогдсон ажлын хэсэг зохион байгуулж сонгон шалгаруулалтын дүнг баталгаажуулан холбогдох материалыг оюутан хариуцсан нэгж болон холбогдох нэгжид хүргүүлнэ.

5.4 Гадаад, дотоодын байгууллага, сан, төгсөгч, хувь хүний нэрэмжит тэтгэлгийн хувьд анхан шатны шалгаруулалтыг МУИС-иас томилогдсон ажлын хэсэг зохион байгуулж, эцсийн шатны шалгаруулалтыг тэтгэлэг олгогч тал хийж сонгогдсон суралцагчдын нэрсийг батлан Оюутан хариуцсан нэгжид хүлээлгэн өгнө.

5.5 Ажлын хэсэг суралцагчдын сурлагын амжилтыг дээшлүүлэх, тэдний эрдэм шинжилгээний ажил хийх, авьяас чадварыг хөгжүүлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих, урамшуулах зарчмыг баримтлан ажиллана.

5.6 Шаардлагатай нөхцөлд тэтгэлэгт нэр дэвшигчтэй ярилцлага хийж болно.

5.7 Тэтгэлэгт хүсэлт ирүүлсэн суралцагчдын материалыг буцаан олгохгүй бөгөөд тэтгэлэгт тэнцээгүй суралцагчдын материалыг нэг сарын турш хадгална.

ЗУРГАА. Тэтгэлэг олгох, батламж гардуулах

6.1 Оюутан хариуцсан нэгж болон холбогдох нэгж нь тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагчдад шалгаруулалтын дүнг мэдээлж, мэдээллийг МУИС-ийн цахим хуудсанд байршуулна.


6.2 Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлгийн батламжийг Эрдмийн зөвлөлийн хуралдаан эсвэл тэргүүлэгчдийн хуралдааны үеэр гардуулна.

6.3 МУИС-ийн нэрэмжит тэтгэлгийн батламжийг хичээлийн жилийн нээлтийн ёслол эсвэл оюутны эрхийн өдрөөр гардуулна.

6.4 Бусад байгууллага, сан, төгсөгч, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлгийг гардуулах ёслолын ажиллагааг тухайн байгууллага, хувь хүмүүстэй байгуулсан гэрээ, харилцан ойлголцлын санамж бичигт заасны дагуу дангаар, эсвэл хамтран зохион байгуулна.

6.5 Суралцагчдад тэтгэлэг олгох тухай захирлын тушаалыг оюутан хариуцсан нэгж, холбогдох нэгж боловсруулан гаргах бөгөөд тушаалд оюутны овог, нэр, бүрэлдэхүүн сургууль, бүртгэлийн дугаар, тухайн улиралд сонгон судлах багц цагийн мэдээллийг тусгасан байна.

6.6 Тэтгэлгийг суралцагчийн сургалтын төлбөрөөс бусад зориулалтаар ашиглахгүй—бөгөөд харьяалагдах бүрэлдэхүүн, салбар сургуулийн дансанд шилжүүлж олгоно.



ДОЛОО. Тэтгэлгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр

7.1 Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлгийн олгох хэмжээ, хэлбэрийг Эрдмийн зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаар баталж МУИС-ийн тухайн жилийн төсөвт тусгана. Бакалаврын болон ахисан түвшний суралцагчдад зохистой харьцаагаар олгоно.

7.2 МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг, докторын сургалтад суралцаж буй МУИС-ийн багшид олгох тэтгэлэг, докторын дараах судлаачийн тэтгэлэг, сургалт, судалгааны туслах ажиллуулах тэтгэлгийн тоо хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн хүрээнд МУИС-ийн захиргааны зөвлөл батална.

7.3 Бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэтгэлгийн төрөл, тоо хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн хүрээнд тухайн сургуулийн захирал батална.

7.4 Суралцагчдад олгох тэтгэлгийн санхүүжилтийн эх үүсвэр нь нээлттэй, тодорхой байх, улс төр, шашны үйл ажиллагааг сурталчлахад чиглэгдээгүй байх шаардлагатай.

7.5 Тэтгэлгийн хэмжээ, санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

7.5.1 МУИС-ийн болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн төсөвт тусгагдсан өөрийн хөрөнгийн эх үүсвэр,

7.5.2 Гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсийн хандив, тусламж,

7.5.3 Бусад эх үүсвэр.

7.6 Тэтгэлэг олгогч байгууллага, хүмүүс нь тэтгэлгийн санхүүжилтийг суралцагчид шууд гардуулах, эсвэл МУИС-иар уламжлан олгож болно.

7.7 Тэтгэлгийн санхүүжилтийн хэлбэрээс шалтгаалан МУИС-иар уламжлан тэтгэлгийг олгох тохиолдолд шийдвэрийг МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

7.8 Тэтгэлгээс суутгал тооцохгүй бөгөөд санхүүжүүлэгч нь тэтгэлгийн санхүүжилтийг МУИС-ийн дансанд валютаар болон төгрөгөөр хийж болох бөгөөд валютаар хийсэн тохиолдолд тэтгэлэгт хамрагдсан суралцагчид тухайн өдрийн Монгол банкны валютын ханшаар хөрвүүлэн тооцож олгоно.

7.9 МУИС-ийн тэтгэлэгт хамрагдсан суралцагчийн илүү төлөлтөөс хувиараа төлсөн төлбөрийг буцаан олгох ба тэтгэлэгтэй холбоотой илүү төлөлтийг суралцагчид олгохгүй.

НАЙМ. Тэтгэлгийг үргэлжлүүлэх, түдгэлзүүлэх, цуцлах


8.1 Тэтгэлгийн төрлөөс хамаарч тэтгэлгийг үргэлжлүүлэн олгох нөхцөл, шаардлага тавигдана.

8.2 Тэтгэлгийг үргэлжлүүлэн олгох тохиолдолд суралцагчийн сурлагын голч дүнгийн мэдээлэл болон холбогдох бусад материалыг оюутан хариуцсан нэгж нягтлан хянаж, баталгаажуулна.

8.3 Суралцагч хүндэтгэх шалтгааны улмаас чөлөө авсан тохиолдолд тэтгэлгийн төрлөөс хамаарч тэтгэлгийг түдгэлзүүлж болно.

8.4 Тэтгэлэгт хамрагдсан боловч захиргааны болон гэмт хэргийн зөрчил гаргасан, бусад шалтгаанаар сургуулиас түр чөлөөлөгдсөн, сурлагын амжилт буурсан, тэтгэлэгт хамрагдахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн г.м. шалтгаанаар тэтгэлгийг үргэлжлүүлэн олгох боломжгүй нь тогтоогдсон нөхцөлд тэтгэлэг олголтыг МУИС-ийн захирлын тушаалаар цуцална.

Захирлын 2021 оны 17 дугаар сарын 09-ны
өдрийн 171 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



МУИС-ИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛГИЙН ЖУРАМ

НЭГ. Тэтгэлгийн зориулалт

1.1 МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг нь тус их сургуульд суралцаж буй бакалавр, магистр, докторын түвшний суралцагчдын сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, амжилттай суралцаж буй шилдэг суралцагчийг урамшуулах, зарим мэргэжлээр элсэгчдийг дэмжих зорилготой.

1.2 Тэтгэлгийг хоёр дахь дээд боловсролын зэрэг эзэмшихээр суралцаж байгаа болон эчнээ, орой хэлбэрээр суралцаж буй суралцагчдад олгохгүй.

1.3 Тэтгэлэгт хамрагдсан суралцагч хос мэргэжлээр суралцах тохиолдолд зөвхөн суурь мэргэжлээр суралцахад нь зориулан тэтгэлэг олгоно.

ХОЁР. Тэтгэлгийн төрөл, нэр дэвшүүлэх, шалгаруулах

2.1 МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:

2.1.1 Олимпиадын нөхцөлөөр элссэн элсэгч,

2.1.2 Элсэлтийн шалгалтын өндөр үнэлгээгээр элссэн элсэгч,

2.1.3 Байгалийн ухааны салбарын хөтөлбөр сонгон элссэн суралцагч,

2.1.4 МУИС-д элссэн Монгол угсаатан гадаад иргэн,

2.1.5 Сурлагын амжилтаар тэргүүлсэн бакалаврын болон ахисан түвшний суралцагч,

2.1.6 Суралцаж буй чиглэлээрээ олон улсын мэргэжлийн олимпиад, эрдэм шинжилгээний хуралд оролцож амжилт үзүүлсэн суралцагч.

2.2 МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг жил бүрийн 10 дугаар сард, ахисан түвшний тэтгэлэг 10 болон 4 дүгээр саруудад тус тус зарлагдана. Тэтгэлэг зарлагдсан тухай зар, мэдээллийг МУИС-ийн албан ёсны веб сайт болон сургалтын Сиси мэдээллийн системээр түгээнэ.

2.3 Тэтгэлэгт мэргэжлийн тэнхим, удирдагч профессор багш нэр дэвшүүлэх ба суралцагч өөрийгөө дэвшүүлэн өрсөлдөх боломжтой.

2.4 Элсэгчдэд зориулсан тэтгэлгээс бусад “МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг”-т нэр дэвшигчдийг нийтлэг журмын 4-р бүлэгт заасны дагуу бүртгэж, 5-р бүлэгт заасны дагуу сонгон шалгаруулна.

ГУРАВ. Тэтгэлгийн шалгуур, хэмжээ, тэтгэлэг олгох

3.1 Суралцагчдад тэтгэлгийн батламжийг “МУИС-д суралцагчдад тэтгэлэг олгох ерөнхий журам”-ын 6.3-д заасны дагуу гардуулна.

3.2 Тухайн хичээлийн жилд олгох тэтгэлгийн төрөл, тоо хэмжээг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.

3.3 Тэтгэлгийн төрлөөс хамааран шалгуур үзүүлэлт болон хэмжээ дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- 3.3.1 Олимпиадын нөхцөлөөр элссэн элсэгчийн шалгуур: Улсын олимпиадад эзэлсэн байрыг нь харгалзан МУИС-д шинээр элсэгчид эхний хичээлийн жилийн тэтгэлгийг дараах харьцаагаар олгоно.
Үүнд:
- 3.3.1.1 I байр: сургалтын төлбөрийн 100 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг,
- 3.3.1.2 II байр: сургалтын төлбөрийн 75 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг,
- 3.3.1.3 III байр: сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг,
- 3.3.1.4 Олон улсын олимпиадад шагналт байр эзэлж, медаль хүртсэн элсэгчид улсын олимпиадын 1-р байранд шалгарсан суралцагчийнхтай ижил хэмжээний тэтгэлэг олгоно.
- 3.3.2 Элсэлтийн шалгалтын өндөр үнэлгээгээр элссэн элсэгчийн шалгуур:
- 3.3.2.1 Суурь шалгалтад тооцуулсан ЭЕШ нь 780 буюу түүнээс дээш оноо авч Хууль зүйн сургууль, Бизнесийн сургууль, Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуульд элссэн, 750 болон түүнээс дээш оноо авч Шинжлэх ухааны сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль, Завхан, Эрдэнэт сургуульд элссэн, Байгаль эх лицей сургуулиас элсэгчдийн хувьд суурь шалгалтад тооцуулсан ЭЕШ-ын үнэлгээ 650 болон түүнээс дээш оноо авч Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуульд элссэн бол эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг нэг удаа олгоно. Тухайн жилд олгох тэтгэлгийн тоо хэмжээнээс хамаарч ЭЕШ-ын суурь болон дагалдах шалгалтын дундаж оноог 2 дахь шалгуур үзүүлэлт болгож болно.
- 3.3.3 Байгалийн ухааны салбарын хөтөлбөр сонгон элссэн суралцагчийн шалгуур:
- 3.3.3.1 Суурь шалгалтад тооцуулсан ЭЕШ нь 700 буюу түүнээс дээш оноо авч ШУС-ийн БУС-ын Багц-2-д элссэн, цаашид суралцагчийн сурлагын голч дүн 3.2 болон түүнээс дээш оноотой суралцсан тохиолдолд 100 хувийн сургалтын төлбөрийн тэтгэлэг, Суурь шалгалтад тооцуулсан ЭЕШ нь 650 буюу түүнээс дээш оноо авч ШУС-ийн БУС-ын Багц-2-д элссэн, цаашид суралцагчийн сурлагын голч дүн 2.8 болон түүнээс дээш оноотой суралцсан тохиолдолд 50 хувийн сургалтын төлбөрийн тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно.
- 3.3.3.2 ХШУИС-ийн 2+2 хөтөлбөрт элссэн элсэгчийг дэмжих бодлогоор сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно. Дараагийн улирлаас сурлагын голч дүн 2.8 болон түүнээс дээш тохиолдолд сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно.
- 3.3.4 МУИС-д элссэн Монгол угсаатан гадаад иргэний шалгуур:

- 3.3.4.1 МУИС-ийн бакалаврын түвшний сургалтад элссэн Монгол угсаатан гадаад иргэнд эхний улирлын сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг олгоно. Улирал бүр 12 багц цагаас доошгүй хичээл сонгон судалж, 2.8-аас доошгүй голч дүнтэй суралцсан тохиолдолд тухайн улирлын сургалтын төлбөрийн 30 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно. Суралцагч чөлөө авсан тохиолдолд тэтгэлэг цуцлагдана.
- 3.3.4.2 МУИС-ийн ахисан түвшний сургалтад элссэн Монгол угсаатан гадаад иргэнд эхний улирлын сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг олгоно. Танхимын сургалтын 9-өөс доошгүй багц цагийг амжилттай судалж сурлагын голч дүн 3.5-аас доошгүй байх тохиолдолд дараагийн улирлын сургалтын төлбөрийн 30 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно. Зөвхөн Ахисан түвшний суралцагчийн танхимын сургалтад тэтгэлэг олгоно. Суралцагч чөлөө авсан тохиолдолд тэтгэлэг цуцлагдана. 3.3.4.1, 3.3.4.2-д заасан шалгуурт Засгийн газрын тэтгэлэг, оюутан солилцоо болон бусад тэтгэлэгт хамрагдсан суралцагчид хамаарахгүй.
- 3.3.5 Сурлагын амжилтаар тэргүүлсэн бакалаврын болон ахисан түвшний суралцагчийн шалгуур:
- 3.3.5.1 Сүүлийн гурван улирал дараалан 12 багц цагаас доошгүй хичээл сонгон судалж, 3.5-аас доошгүй голч дүнтэй суралцсан бакалаврын түвшний суралцагчид (байгалийн ухаан, инженерчлэлийн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хувьд сурлагын голч дүн 3.2-оос доошгүй байх), сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно.
- 3.3.5.2 Суралцагчийн хувийн төлөвлөгөөнд үндэслэн сүүлийн 2 улирал дараалан 9-өөс доошгүй багц цагийн хичээлийг амжилттай судалж 3.5-аас доошгүй голч дүнтэй суралцсан, эрдэм шинжилгээний багц цагаа биелүүлсэн, магистр, докторын (мэргэжлийн магистрт хамаарахгүй) суралцагчид тухайн улирлын сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг нэг удаа олгоно.
- 3.3.6 Суралцаж буй чиглэлээрээ олон улсын мэргэжлийн олимпиад, эрдэм шинжилгээний хуралд оролцож амжилт үзүүлсэн суралцагчийн шалгуур:
- 3.3.6.1 Олон улсын мэргэжлийн олимпиад, эрдэм шинжилгээний хуралд оролцож, эхний 3 байр эзэлсэн суралцагчид тухайн улирлын сургалтын төлбөрийн 50 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг нэг удаа олгоно. Багаар шалгарсан тохиолдолд багт нь тухайн улирлын сургалтын төлбөрийн 30 багц цагийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг 1 удаа олгоно.


3.4 Хичээлийн жилийн нэг улирлын сургалтын төлбөрийн хэмжээг тухайн хөтөлбөр дэх бакалаврын түвшний хувьд 15 багц цаг, ахисан түвшний хувьд 12 багц цагийн төлбөрөөр тус тус тооцно.

3.5 Суралцагчийн тэтгэлгийг 1-р түвшний суралцагчийн хувьд ерөнхий суурь хичээлийн төлбөрөөр, бусад түвшний суралцагчийн хувьд харгалзах сургуулийн мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлийн төлбөрөөр тооцно. Ахисан түвшний суралцагчийн хувьд сургалтын багц цагийн (диссертацийн төлбөрөөс бусад) төлбөрөөр тооцно.


3.6 Журмын 3.3.3, 3.3.4, 3.3.5.1-д заагдсан чиглэлээр тэтгэлэг авсан суралцагч нь улирал бүр болзлыг биелүүлсэн тохиолдолд тэтгэлгийг үргэлжлүүлэн олгох ба биелүүлээгүй тохиолдолд тэтгэлэг цуцлах нөхцөл болно.

3.7 МУИС болон харьяа бүрэлдэхүүн/салбар сургуультай гадаадын их дээд сургууль, судалгааны байгууллагын хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр гадаад суралцагчийн сургалтын төлбөрийг гэрээнд заасан хувиар хөнгөлөх хэлбэрээр тэтгэлэг олгох ба МУИС-ийн захиргааны зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

3.8 Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор МУИС-ийн нэрэмжит тэтгэлгийг захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн олгож болно.



Захирлын 2021 оны 01 дугаар сарын 09-ны
өдрийн А.1. тушаалын 3 дугаар хавсралт



МУИС-ИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ

НЭГ. Тэтгэлгийн зориулалт

1.1 МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг нь тус их сургуульд суралцаж буй бакалавр, магистр, докторын түвшний суралцагчдын судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэх, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, урамшуулах зорилготой.

1.2 Тэтгэлгийг судалгаа шинжилгээний ажилд идэвхтэй оролцож, профессор багшийн хэрэгжүүлж буй эрдэм шинжилгээний төсөл хөтөлбөрт оролцон судалгааны туслахаар ажилласан, эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцож онцгой амжилт гаргасан, эрдэм шинжилгээний шинэлэг үр дүн бүхий өгүүлэл бичиж хэвлүүлсэн, судалгааны шинжилгээний ажил хийж гүйцэтгэх онцгой авъяастайгаа харуулсан шилдэг суралцагчид олгоно.

ХОЁР. Тэтгэлэгт нэр дэвшүүлэх, шалгаруулах

2.1 Дараах болзлын аль нэгийг хангасан суралцагч МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэгт нэр дэвших боломжтой. Үүнд:

2.1.1 Улсын болон олон улсын чанартай оюутны эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцож эхний 3 байрт шалгарсан суралцагч,

2.1.2 Судалгааныхаа ажлын үр дүнгээр шинэлэг үр дүн бүхий эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн суралцагч,

2.1.3 Шинэ технологи, бүтээгдэхүүн, загвар боловсруулсан суралцагч.

2.2 Тэтгэлэгт тухайн суралцагчийн судалгааны ажлын удирдагч профессор багш, мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургууль нэр дэвшүүлэн өрсөлдүүлэх боломжтой.

2.3 Тэтгэлэгт нэр дэвшигчдийг нийтлэг журмын 4-р зүйлд заасны дагуу бүртгэл материалыг хүлээн авч, 5-р зүйлд заасны дагуу тэтгэлэг олгож батламж гардуулна.


ГУРАВ. Тэтгэлгийн хэмжээ

3.1 Тэтгэлгийн батламжийг Эрдмийн зөвлөлийн хуралдаан дээр суралцагчид эрдмийн зөвлөлийн дарга гардуулна.

3.2 Тэтгэлгийг жилд нэг удаа, 10 хүртэл суралцагчид давхардуулахгүйгээр олгоно.

3.3 Тэтгэлгийн хэмжээ тухайн хичээлийн жилийн МУИС-ийн бакалаврын түвшний сургалтын төлбөрийн дунджийн 60 хувиас хэтрэхгүй байна.

Захирлын 2021 оны 04 дугаар сарын 09 -ны
өдрийн 1174 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт



Ц.ДАМДИНСҮРЭН, Ш.ЛУВСАНВАНДАН, Б.РИНЧЕН НАРЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ

НЭГ. Ерөнхий үндэслэл

3.1 МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 1992 оны 2-р сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу нэрт монгол судлаач Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Б.Ринчен нарын нэрэмжит тэтгэлэг олгоно.

3.2 Тэтгэлгийн зорилго нь монгол судлалын чиглэлээр ажилладаг гадаадын залуу судлаачдыг ахисан түвшний сургалтад хамруулж, мэргэшихэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино. Үүнд:

3.2.1 Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит тэтгэлэг – Монголын утга зохиол, түүх,

3.2.2 Ш.Лувсанвандангийн нэрэмжит тэтгэлэг – Монгол хэл бичиг, эх бичиг судлал,

3.2.3 Б.Ринчений нэрэмжит тэтгэлэг – Утга соёл, угсаатны зүй, хүн судлал.

3.3 Нэрэмжит тэтгэлгийг жилд тус бүр 1-2 хүнд олгоно.

3.4 Суралцагч сургалтын хугацаандаа МУИС-ийн дүрэм, бусад холбогдох журам, зааврыг мөрдөнө.

ХОЁР. Нэрэмжит тэтгэлэгт хамруулах

2.1 Нэрэмжит тэтгэлэгт нэр дэвшигч нь монгол судлалын чиглэлээр докторантурт суралцагч болон докторын дараах судалгааны ажил хийх сонирхолтой 40 хүртэлх насны судлаач байна.

2.2 Суралцагч нь хичээлийн жилийн хугацаанд 3 сараар МУИС-д тодорхой хөтөлбөрийн дагуу ахисан түвшний сургалтанд хамрагдаж, судалгааны ажил хийсэн байна.

2.3 Нэрэмжит тэтгэлгийн мэдээллийг Монгол судлалын хүрээлэн /МСХ/-ээс түгээнэ.

2.4 Нэрэмжит тэтгэлэгт нэр дэвшигч нь доорх материалыг бүрдүүлж, сургалтад хамрагдахаас 3 сарын өмнө МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнд ирүүлнэ.

Үүнд:

2.4.1 Боловсрол, ажлын туршлагыг илтгэх биеийн байцаалт (CV),

2.4.2 Бүтээлийн жагсаалт,

2.4.3 Суралцах зорилго, судалгааны хамрах хүрээг илтгэсэн өргөдөл,

2.4.4 Мэргэжлийн профессорын тодорхойлолт,

2.4.5 Суралцах хугацааны ажлын төлөвлөгөө,

2.4.6 Эрүүл мэндийн үзлэгийн бичиг.

2.5 Монгол судлалын хүрээлэн нь тэтгэлгийн сонгон шалгаруулалтын мэдээллийг МУИС-ийн цахим хуудсанд байршуулна.

ГУРАВ. Тэтгэлэг олгох, шалгаруулах

3.1 Тэтгэлэгт шалгарсан судлаачийн ажилд зөвлөх үүрэгтэй мэргэжлийн эрдэмтнийг зөвлөх профессороор томилж ажиллуулна.

3.2 Нэрэмжит тэтгэлэгт хамрагдах болзол хангасан судлаачид дараах тэтгэлгийг олгоно. Үүнд:

3.2.1 Оюутны байранд амьдрах нөхцөлөөр хангах,


3.2.2 Сар бүр 700.000 төгрөгийн тэтгэлэг олгох,

3.2.3 Орон нутагт судалгааны материал цуглуулах ажлаар явахад нэг удаа 300.000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх.


3.3 Тэтгэлгийн шалгаруулалтыг Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс /ЭШИХ/-ийн төлөөллийг оролцуулсан Монгол судлалын хүрээлэнгээс томилсон ажлын хэсэг хариуцан зохион байгуулна.

3.4 Суралцагч суралцах хугацаандаа судалгааны семинарт идэвхтэй оролцох, илтгэл хэлэлцүүлэх, эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлэх үүрэг хүлээнэ.

3.5 Тэтгэлгээр суралцагч сургалт дуусахаас өмнө буюу сүүлчийн сарын тэтгэлгийг олгохоос өмнө судалгааныхаа ажлын тайланг мэргэжлийн тэнхимийн хурлаар хэлэлцүүлж, Монгол судлалын хүрээлэнд ирүүлнэ.



Захирлын 2021 оны 07 дугаар сарын 09 -ны
өдрийн 4/44 дугаар тушаалын 6 дугаар хавсралт



ДОКТОРЫН СУРГАЛТАД СУРАЛЦАЖ БУЙ МУИС-ИЙН БАГШИД ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. Тэтгэлгийн зориулалт

1.1 “МУИС-д профессор, багш ажиллуулах журам”-ын 3.3-р заалтыг хэрэгжүүлэх, МУИС-д үндсэн багшаар ажиллаж, тус сургуулийн докторын сургалтад амжилттай суралцаж буй багшид төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх хэлбэрээр энэхүү тэтгэлгийг олгоно.

1.2 Тэтгэлгийг докторын сургалтад элсэж, суралцвал зохих хугацаандаа тасралтгүй суралцаж, мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийг судалж, судалгаа шинжилгээний ажилд идэвхтэй оролцож, диссертацийн судалгаагаа хийж буй суралцагчид нэг удаа олгоно.

1.3 Тэтгэлгийг сургалтын төлбөрийн хөнгөлөлт хэлбэрээр, шууд бусаар олгоно.

ХОЁР. Тэтгэлэгт нэр дэвшүүлэх, шалгаруулах

2.1 Дараах болзлыг хангасан суралцагч энэхүү тэтгэлэгт нэр дэвших боломжтой. Үүнд:

2.1.1 Докторын сургалтад элсэн 3-аас доошгүй улирал, 6 жилээс илүүгүй хугацаагаар суралцаж байгаа МУИС-ийн үндсэн багш (Хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааг энд хамруулж тооцохгүй)

2.1.2 Суралцагч судалбал зохих мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийг судалж багц цагаа бүрэн биелүүлсэн байх

2.1.3 Суралцагч мэргэжлийн судалгааны семинарт тогтмол оролцож, диссертацийн судалгаагаа идэвхтэй хийдэг байх

2.2 Тэтгэлэгт тухайн суралцагчийн судалгааны ажлын удирдагч профессор багш нэр дэвшүүлнэ.

2.3 Нэр дэвшигчдийг тэтгэлэгт хамруулах асуудлыг мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж дүгнэлт гарган, шаардлага хангасан тохиолдолд холбогдох бичиг баримтыг хурлын тэмдэглэл, шийдвэрийн хамт Ахисан түвшний сургуульд хүргүүлнэ.

2.4 Ахисан түвшний сургуулиас бүрэлдэхүүн сургууль бүрээс төлөөлөл бүхий профессор, дэд профессор багш нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулан МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулж сонгон шалгаруулалтыг явуулна.

2.5 Тэтгэлэг олгох тухай ажлын хэсгийн дүгнэлтийг МУИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, захирлын тушаалаар баталгаажуулна.

ГУРАВ. Тэтгэлгийн хэмжээ

- 3.1 Тэтгэлгийг нэг удаа, суралцагчид давхардуулахгүйгээр олгоно.
- 3.2 Докторант багшид олгох тэтгэлгийн хэмжээ нь үзүүлсэн амжилтаас шалтгаалан ялгаатай байна. Үүнд:
- 3.2.1 Сурлагын голч 3.5-аас бага бол эрдэм шинжилгээний ажлын 4 багц цаг болон диссертацийн ажлын 10 багц цагийн төлбөр
 - 3.2.2 Сурлагын голч 3.5 ба түүнээс дээш бол эрдэм шинжилгээний ажлын 6 багц цаг болон диссертацийн ажлын 10 багц цагийн төлбөр
 - 3.2.3 Мэргэжлийн түвшинд хянагддаг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн бол эрдэм шинжилгээний ажлын 8 багц цаг, диссертацийн ажлын 14 багц цаг
 - 3.2.4 Голч дүн нь 3.5 ба түүнээс дээш, мэргэжлийн түвшинд хянагддаг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн бол эрдэм шинжилгээний ажлын 12 багц цаг болон диссертацийн ажлын 18 багц цагийн төлбөр

